**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВИЛГЫН ЭСРЭГ**
**2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023.12.08 Өвт

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих | Үнэлгээний хувь |
|---|---|---|---|---|
| | | **ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ** | | |
| 1 | **Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сургалчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх.** | 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас, болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх. | **Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг цахим хуудас, болон фейсбүүк, мэдээллийн самбаруудаар дамжуулан иргэдэд хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж БИНХуралуудаар авлига албан тушаалтны чиг үүргүүдийн талаар танилцуулж, авлига ашиг сонирхлоос ангид байхад иргэдийн оролцоо мэдээлэл чухал үүрэгтэйг сурталчлан ажилласан.**    | 100 |
| | | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах. | Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах байгууллагын зүгээс нийт албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийг бууруулах, нүүр тулсан харилцааг багасгах төрийн үйлчилгээг цахимжуулах, ил тод, нээлттэй, түргэн шуурхай болгох талаар сургалт, төсвийн ил тод байдал, төрийн албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, гүйцэтгэх чиг үүргүүдийн талаар сургалтууд зохион байгуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | |   | |
| | | 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах. | “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар буланг иргэд олноор цуглардаг газарт буюу Засаг даргын Тамгын газарт байрлуулан, шаардагдах мэдээллийг тухай бүр нь цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн ажиллуулж байна. Уг булангаар 5-6 төрлийн мэдээллийг хүргэж ажилласан.   | 100 |
| | | 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгаа хийж олон нийтэд хүргэсэн байх. | Олон нийтийн сүлжээ, цахим хуудас, фейсбүүк, гарын авлага, броюшур зэргээр авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлан ажилласан.   | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд төрийн албанд шинээр томилогдсон удирдах албан тушаалтан болон төрийн албан хаагчдад Авлигын эсрэг хууль болон бусад хууль, тогтоомжийн талаар сургалт хийж авлигын эсрэг сургалтад суух шаардлагатайг анхааруулж зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.  | 100 |
| | | 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сумын Төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт сумын Засаг даргын 2023 оны 1/76 дугаар албан бичгээр үүрэг чиглэл өгч, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн. Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг өгөв. Сургалт, мэдээлэлд 120 албан хаагч хамрагдав.   | 100 |
| 3 | Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | Сумын ЗДТГазраас аж ахуй нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалт тусгаж, хэрэгжүүлэн ажилласан. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах. | 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | **Сумын Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг байгууллагын цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод болгож ажилласан. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр олон нийтэд сурталчлан төрийн албан хаагчдыг сургалт мэдээллээр хангаж, өдөр тутамд нь зөвлөгөө өгч ажиллаж байна.**  | 100 |
| | | 4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх. | **Салбарын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудасны эрх зүйн акт болон хууль, эрх зүйн буланд тогтмол байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Салбар байгууллагуудын авлигын сэрэг төлөвлөгөөнд тусгаж хяналт тавин хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн төрийн албан хүнд суртал шалтгаан нөхцөлийн талаар байгууллагуудын удирдлагуудад болон албан хаагчдадаа зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.** | 90 |
| | | 4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | Иргэдээс төрийн албан хаагчдын үзүүлж буй үйлчилгээ, хүнд суртал, ёс зүй, харилцаа, хандлагын талаар сэтгэл ханамжийн судалгааг авч анализ, дүгнэлт хийж төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл, хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зэрэг ажлуудыг зохион байгуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | |  | |
| 5 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах. | Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдад тайлагнасан. | 90 |
| | | 5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх. | Авлигатай тэмцэх газар, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/713 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг тухай жилийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 6 | Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах. | 6.1. Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох зүйл заалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Прокурорын газар, авлигын эсрэг сургагч багш нартай хамтран төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад сургалт, мэдээлэл өгч, зөвлөмж чиглэл хүргүүлэх. | 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Сумын ГХУСАЗСЗөвлөлөөс төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор СӨББ-1, СӨББ-2-ын албан хаагчдад Авлигын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх, сумын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн талаарх ерөнхий мэдээлэл, үйлдэгдэж буй шалтгаан нөхцөл, Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг, Хүүхдийн эрхийн тухай хууль зэрэг сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 2 байгууллагын 48 албан хаагч хамрагдсан. | 100 |
| | | 6.2. Эрсдэл бүхий зарим төрийн байгууллагыг сонгон авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах чиглэлээр тусгайлан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах. | Засаг даргын Тамгын газар, ЕБС, СӨББ 1, 2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн нийт 132 албан хаагчдад авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж сургалт хийсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | |    | |
| | | 6.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг арилгах. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох албан хаагчдаар жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж хэвшсэн. ХАСХОМ-ыг хугацаа хоцроосон мэдүүлэг гаргаагүй. | 100 |
| **Нийт хувь** | | | | **98** |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ